



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аян зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх, албан хаагчдад хууль тогтоомжийг таниулан сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяныг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд байгууллагын хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяны удирдамжийг 1 дүгээр, Аяныг зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг 2 дугаар, Албан хаагчдын судалбал зохих хууль, эрх зүйн актын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяны удирдамж, нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг уялдуулан, удирдлага, зохисн байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг газрын даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

133013713

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 10 сарын 25-ны өдрийн А/ЛБ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**“Бид - ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭСЭН, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛӨӨС АНГИД ХАМТ ОЛОН” АЯНЫ
У Д И Р Д А М Ж**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)-ын хэмжээнд аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг энэхүү удирдамжийн дагуу зохион байгуулна.

Нэг. Зорилго

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын ёс зүйг эрхэмлэх, ажлын гүйцэтгэл, үр дүн, хариуцлага, сахилгыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилтийг хангахад чиглэсэн эрх зүйн мэдлэг, ойлголтыг ахиулах, тэдний идэвх, оролцоог нэмэгдүүлж, санал санаачилгыг дэмжихэд аяны зорилго оршино.

Хоёр. Аяны уриа

Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас **“2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил”** болгон зарласантай холбоотой уг жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх Авлигатай тэмцэх таван үйл ажиллагааны үзэл санааг аяны зорилготой уялдуулж, уг жилийн ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулж байгаа “Авлигын эсрэг НЭГДЬЕ” нөлөөллийн аяны урианы дор нэгдэнэ.

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяны уриа: **“Авлигын эсрэг НЭГДЬЕ!”**

Гурав. Хугацаа, хамрах хүрээ

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяныг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэмжээнд зохион байгуулж, нийт албан хаагчийг бүрэн хамруулна.

Дөрөв. Зохион байгуулах ажлын чиглэл

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяныг зохион байгуулах ажлын хүрээнд дараах чиглэлийг баримтална. Үүнд:

1. Төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, ойлголтыг ахиулах, авлига, ашиг сонирхлын зөрчил, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүнг

- дээшлүүлэх, ёс зүй, сахилга, хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэсэн хууль тогтсомжийг дагаж мөрдөхөд анхаарах асуудлуудыг таниулан сурталчлах;
2. Заавал судалбал зохих хууль, эрх зүйн актын жагсаалтыг гарган албан хаагчдад танилцуулж, судлуулах ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах;
 3. Албан хаагчдын ажил үүрэгтэй нь холбогдуулан эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, тэдний оролцоог хангахад чиглэсэн зөрчил, дутагдал, аливаа эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;
 4. Хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэр, холбогдох журам, дүрэм, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг албан хаагчдад тайлагнан мэдээлэх, уялдаа холбоог хангуулах;
 5. Албан хаагчдын санал, бодлыг сонсох боломжийг бий болгох, албан хаагчид болон хэлтсийн идэвх санаачилгыг дэмжих.

Тав. Зохион байгуулалтын талаар

Аян хүрээнд зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөний дагуу аяныг удирдлага, зохион байгуулалтаар хангана.

Байгууллагын зүгээс нийтлэг байдлаар зохион байгуулах нэгдсэн ажил, арга хэмжээнээс гадна хэлтсүүдээс албан хаагчдынхаа идэвх, оролцоог тэгш хангах, шинэлэг, сонирхолтой арга хэмжээнүүдийг санаачлан зохион байгуулах, бүтээлч хандлагыг бий болгох боломжийг бүрдүүлнэ.

Хэлтэс бүр аяны хугацаанд хуваарийн дагуу тухайн 7 хоногийн 5 өдрийг хариуцан энэхүү удирдамж, нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт албан хаагчид болон иргэд, олон нийт, харьяа байгууллагад хандсан тодорхой ажлыг санаачлан зохион байгуулна.

Хэлтсүүдийн хариуцах 5 хоногийн хуваарь:

Хэлтэс	Хариуцах 5 хоног (Ажлын өдрөөр)
1. Захиргаа, удирдлагын хэлтэс	2023.10.30 – 2023.11.03
2. Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс	2023.11.06 – 2023.11.10
3. Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс	2023.11.13 – 2023.11.17
4. Хууль, эрх зүйн хэлтэс	2023.11.20 – 2023.11.24
5. Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс	2023.11.27 – 2023.12.01

Хэлтсүүд өөрийн хариуцах хуваарьт өдрүүдэд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган ажиллана. Аяны хүрээнд зохион байгуулах мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг өглөөний 9:00 – 9:30 цагийн хооронд зохион байгуулах чиглэл баримтална.

Зургаа. Аяны ажлыг дүгнэх, тайлагнах

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяны хүрээнд өөрсдийн санаачилж зохион байгуулсан ажлын талаарх тайлангаа баримт материал, гэрэл зураг гэх мэт баримтаар нотлон баримтжуулж, Захиргаа, удирдлагын хэлтэст нэгдсэн төлөвлөгөөнд заасан хугацаанд ирүүлнэ.

Аянд оролцсон хэлтсүүдийн идэвх, оролцоог тодорхой баримт, нотломжийг үндэслэн дүгнэж, дүнг жилийн эцэст “Оны шилдэг хэлтэс”-ийг шалгаруулахад харгалзана.

Зохион байгуулагдсан тодорхой арга хэмжээний хүрээнд албан хаагчдын идэвх, оролцоог дүгнэж, урамшуулан, албан хаагчийн 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэхэд харгалзана.

Аяны хүрээнд зохион байгуулагдах аливаа арга хэмжээг баримт бичиг, гэрэл зураг, видео гэх зэрэг олон төрлийн нотломжоор баримтжуулсан байна.

Тайлан, үр дүнг нэгтгэн гаргаж, газрын даргын Зөвлөлд танилцуулан баталгаажуулна.

Долоо. Хүлээгдэж буй үр дүн

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяныг зохион байгуулсны үр дүнд,

1. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачилгыг Авлигатай тэмцэх газраас үнэлэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт хангагдана.
2. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа олон талт хэлбэрээр өргөжиж, тодорхой үр нөлөө үзүүлнэ (Тухайлбал, Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангагдах; албан хаагчид ёс зүй, аливаа гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлээс ангид байх).
3. Хэлтэс, хамт олон, албан хаагчийн идэвх оролцоо нэмэгдэж, албан хаагчид, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд ахиц гарна.
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдана.
5. Хамт олны дундаас гарсан шинэлэг, бүтээлч ажлуудыг цаашид байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, мөрдөх, хэвшүүлэх санал, санаачилга, хүсэл эрмэлзэл бий болно.

_____ о О о _____

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 10 сарын ...-ны өдрийн А.Д.Б... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“БИД – ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭСЭН, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД ХАМТ ОЛОН” АЯНЫ ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ



Д/д	Ажил, арга хэмжээ	Хариуцах хэлтэс, албан тушаалтан	Хугацаа	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	Үр дүнг тайлагнах шалгуур үзүүлэлт
-----	-------------------	----------------------------------	---------	---	------------------------------------

Нэг. Хууль тогтоомж сурталчлах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд

1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн талаар мэдээлэл хийх	Захиргаа, удирдлагын хэлтэс (ЗУХ)	2023.10.30 – 2023.11.03	<ul style="list-style-type: none">- Мэдээллийг 2 удаа хийсэн байна.- Хэлтэс, албан хаагчдын үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан байна.- Холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлт хангагдана.- Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.	1.Холбогдох материал, ирц бүртгэл, гэрэл зураг зэрэг нотлох баримтуудыг тайланд хавсарган нотолж баримтжуулна.
		Төрийн өмчийн ашиглалтын хэлтэс (ТӨБАХ)	2023.11.06 – 2023.11.10		
		Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (ТӨХШХ)	2023.11.13 – 2023.11.17		
		Хууль, эрх зүйн хэлтэс (ХЭЗХ)	2023.11.20 – 2023.11.24		
	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (ТӨҮЗХ)	2023.11.27 – 2023.12.01			

2	Хууль тогтоомж сурталчлан таниуллах сургалт зохион байгуулах Үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйл; • Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйл.	ЗУХ	2023.10.30 – 2023.11.03	- Сонгосон хууль тогтоомжийг сурталчилсан 2< арга хэмжээг зохион байгуулсан байна. - Холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлт хангагдана. - Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.	1.Хууль тогтоомж сурталчлан таниулахад ашигласан ppt файл бүхий танилцуулгыг дотоод сүлжээний https://www.able.mn -ийн "Олон нийтийн" цэсний файлыг хэргийн санд байршуулсан байх; 2.Сургалтын материал, ирц бүртгэл, гэрэл зураг зэрэг нотлох баримтуудыг тайланд хавсарган баримтжуулна.
		ТӨБАХ	2023.11.06 – 2023.11.10		
		ТӨХШХ	2023.11.13 – 2023.11.17		
3	Албан хаагчдын судалбал зохиох хууль, эрх зүйн актыг судалж, аяны хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд идэвхтэй оролцох	Хэлтэс, албан хаагчид	Аяны хугацаанд	- Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг, ойлголт дээшилсэн байна.	Судалбал зохиох хууль, эрх зүйн актыг судалсан эсэх талаар санал, сэтгэгдэл авах, гарын үсэг авч нотлох баримт бүрдүүлж, тайланд тусгасан байна.
		Хоёр. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлын хүрээнд			
4	Байгууллагын албан хаагчдын дунд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	ЗУХ	2023.10.30 – 2023.11.03	- Сонирхолтой, бүтээлч хэлбэр, агуулгаар зохион байгуулагдсан байна.	Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.
		ТӨБАХ	2023.11.06 – 2023.11.10	- 1< арга хэмжээг зохион байгуулсан байна.	Нотгомж бүхий баримт материал, гэрэл зураг зэргийг тайланд хавсаргасан байна.
		ТӨХШХ	2023.11.13 – 2023.11.17	- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	
		ХЭЗХ	2023.11.20 – 2023.11.24		

		ТӨҮЗХ	2023.11.27 – 2023.12.01		
		ЗУХ	2023.10.30 – 2023.11.03	- Сонирхолтой, бүтээлч хэлбэр, агуулгатай байна.	
		ТӨБАХ	2023.11.06 – 2023.11.10	- 1 < арга хэмжээг зохион байгуулсан байна.	Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.
		ТӨХШХ	2023.11.13 – 2023.11.17	- Холбогдох тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Нотгомж бүхий баримт материал, гэрэл зураг зэргийг хавсаргасан байна.
		ХЭЗХ	2023.11.20 – 2023.11.24	- Үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдана.	
		ТӨҮЗХ	2023.11.27 – 2023.12.01	- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана.	
5	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой харьяа хуулийн этгээдэд болон олон нийтэд хандаж нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах				
6	Улсын хэмжээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа “Авлигын эсрэг НЭГДЭ” аянд нэгдсэн агуулга бүхий сурталчилгааг олон нийтийн сүлжээний фэйсбүүк хаягаараа сурталчлах	Хэлтэс, албан хаагчид	Аяны хугацаанд	- Холбогдох тогтоомжийн хэрэгжилт хангагдана. - Олон нийтэд нөлөөлөх мэдээлэл сурталчилгаа болсон байна. - Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана.	Нотгомж бүхий баримт материал, гэрэл зураг зэргийг хавсаргасан байна.
Гурав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд					
7	Байгууллагын албан ёсны цахим хуудас https://rcsp.gov.mn дахь холбогдох Цэсүүдийн мэдээллийг өөрийн хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр баяжуулах	Хэлтсүүд	Аяны хугацаанд	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана. - Байгууллагын ил тод ажиглалааны ил тод үйл	Хэлтсүүд тайланд Нотгомж бүхий мэдээллийг агуулж тайлагнана.

	(Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд хяналт тавьсан байна)				Байдлын үзүүлэлтийн хэрэгжилт, зохион байгуулалт сайжирна.	
8	Хариуцсан чиг үүрэг, үйл ажиллагааны талаар, аяны хүрээнд хийж байгаа ажлын мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт мэдээлж, сурталчлах	ЗУХ	2023.10.30 – 2023.11.03	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Тайланд нотлох баримт, гэрэл зураг бүхий материалгаар нотолж хавсаргасан байна.	
		ТӨБАХ	2023.11.06 – 2023.11.10	- Байгууллагын ил тод байдлын хэрэгжилт, үзүүлэлтийн хэрэгжилт, зохион байгуулалт сайжирна.		
		ТӨХШХ	2023.11.13 – 2023.11.17			
		ХЭЗХ	2023.11.20 – 2023.11.24			
		ТӨҮЭХ	2023.11.27 – 2023.12.01			
Дөрөв. Зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний хүрээнд						
9	"Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон" аяны нээлтийг хийж, нийт албан хаагчдад удирдамж, төлөвлөгөөг танилцуулах, хүргүүлэх	ЗУХ-ийн дарга Н.Ганболд		- Холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангагдана.	Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.	
		ЗУХ-ын ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг	2023.10.25	- Байгууллагын ажлын үзүүлэлт хангагдана.	Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.	
10	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан аливаа гэрээний нөхцөлд	ЗУХ-ийн мэргэжилтэн Д.Цэрэнлхам	2023.11.01 – 2023.11.10	- Холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангагдана.	Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.	

	авлигаас урьдчилсан сэргийлэх асуудлыг тусгасан эсэхэд хяналт хийж, дүгнэлт гарган авах арга хэмжээг тодорхойлох	ХЭЗХ-ийн мэргэжилтэн Х.Нарангарав		- Байгууллагын авлигын эсрэг үйл төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт хангагдана. - Байгууллагын дотоод хяналт, үйл ажиллагааны зорилт хэрэгжихэд үр нөлөөтэй.	
11	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар судлах	ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг	2023.11.01 – 2023.12.08	- Байгууллагын авлигын эсрэг үйл төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагыг хангах чиглэлийг тодорхойлсон байна. - Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангахад ахиц гарсан байна.	Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна. Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.
12	Байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлын талаар олон нийтийн санал асуулга авах	ЗУХ-ий ахлах мэргэжилтэн Г.Туул МТД-ны ажилтан М.Нямсүрэн	Аяны хугацаанд	- Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор журмын хэрэгжилтийг хангасан байна. - Байгууллагын үйл ажиллагааны тодорхой чиглэлд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.	Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.

<p>13</p> <p>Давхар ажил эрхлэлттэй холбоотой хориголт хязгаарлалтын хэрэгжилтэд хяналт тавьж, 2023 оны давхар ажил эрхлэлтийн байдлын судалгаа авч, нэгтгэн танилцуулах</p>	<p>ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг</p>	<p>2023.11.19 – 2023.12.05</p>	<p>- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.6-д заасан заалтын хэрэгжилт хангагдана.</p>	<p>Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.</p>
<p>14</p> <p>Харьяа төрийн өмчит компани, үйлдвэрийн газарт авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөмж боловсруулж хүргүүлэх</p>	<p>ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг ТӨУЭХ-ийн ахлах мэргэжилтэн (Албаны дарга) В.Дарханбаатар</p>	<p>2023.11.10-ны дотор</p>	<p>- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.</p>	<p>Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.</p>
<p>15</p> <p>“Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх нь” сургалт зохион байгуулах</p>	<p>ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Г.Туул, Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Дагиймаа</p>	<p>2023.12.04</p>	<p>- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан журмыг танилцуулсан байна. - Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтарсан байна. - Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна.</p>	<p>Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.</p>
<p>16</p> <p>Хэлэлцүүлэг зохион байгуулах (Сэдэв: Ёс зүй, хандлага, байгууллагын соёл, шударга байдал г.м.)</p>	<p>Ёс зүйн зөвлөл</p>	<p>2023.12.06</p>	<p>- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах санал санаачилга бий болсон байна.</p>	<p>Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.</p>

				<ul style="list-style-type: none"> - Асуудлыг тодорхойлох боломж бүрдэнэ. - Авлигын эсрэг үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангана. - Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна. 	
17	Хууль, эрх зүйн зөрчил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сурталчилгаа бэлтгэж, олон нийтэд хүргэх	Хэвлэл мэдээллийн ажиглан М.Эрдэнэчимэг Хэлтсийн дарга нар	Аяны хугацаанд	<ul style="list-style-type: none"> - 1 < уриалга бүхий сурталчилгааны материал бэлтгэж олон нийтэд түгээсэн байна. 	Тайланд холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.
18	Аяны нэр, урианы дор нэгдэж, эв нэгдлийг эрхэмлэн, зөрөл хандлагыг түгээх үзэл санааг дэлгэрүүлэх "Спортын нэгдсэн өдөрлөг"-ийг зохион байгуулах	Олон нийтийн ажлын комисс	2023.11.08	<ul style="list-style-type: none"> - Аяны нэр, урианы дор нэгдсэн байна. - Өдөрлөгийн үеэр зохион байгуулах тэмцээний удирдамжийг тусгайлан батлуулсан байна. - Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна. 	Өдөрлөгийн үеэр нөлөөллийн сурталчилгаа, ухуулга зохион байгуулсан талаар нотлох баримт бүхий мэдээллийг тайланд тусгасан байх.
19	Хууль, тогтоомжийн мэдлэг сорих, танин мэдэхүйн чиглэлээр албан хаагчдын дунд АХД тэмцээн-уралдааныг зохион байгуулах	ЗУХ, ХЭЗХ	2023.12.07	<ul style="list-style-type: none"> - Аяны хаалтын арга хэмжээ болгон зохион байгуулсан байна. - Сонирхолтой, бүтээлч агуулгаар баяжуулсан байна. 	Зохион байгуулсан ажлыг олон нийтэд мэдээлсэн байна. Тайланд нотлох баримт, материалыг хавсаргасан байна.

Тав. Аян зохион байгуулалт, дүнг нэгтгэн танилцуулах ажлын хүрээнд

20	Аяны нийтлэг арга хэмжээнд шаардлагатай төсвийн тооцоо гаргах, шийдвэрлүүлэх	Ерөнхий нягтлан бодогч Д.Отгонтуяа ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг Олон нийтийн комисс	2023.10.25-27	- Зардлын төсөв тооцоог баталсан байна. - Зарцуулалтын тайлан тооцоог гаргасан байна.	Нотгомж бүхий баримт материалыг тайланд хавсаргасан байна.
21	Нэгдсэн арга хэмжээний үеэр ашиглагдах баннер, зуралт хуудас, бусад материал зэргийг хэвлүүлэх	ЗУХ, Х.Энхчимэг Д.Цэрэнлхам Д.Улам-Ундрах У.Усгал	2023.10.25-30	- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн загвар, лого, аяны онцлогийг тусгасан байна. - Зохион байгуулагдах ажил, арга хэмжээнд ашигласан байна. - Олон нийтэд түгээсэн байна.	Нотгомж бүхий баримт материалыг тайланд хавсаргасан байна.
22	Аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа ажил, арга хэмжээний таглаар хэвлэлийн мэдээ, мэдээллийг бэлтгэж, олон нийтэд мэдээлэх	Хэвлэл мэдээллийн ажилтан Н.Эрдэнэчимэг	Аяны хугацаанд	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Нотгомж бүхий баримт материалыг тайланд хавсарган ирүүлсэн байна.
23	Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын таглаарх тайлан мэдээллийг боловсруулж, нотгомж, баримт мэдээллийн хамт	Хэлтсийн дарга нар	2023.12.06	- Аяны хүрээнд өөрсдийн зохион байгуулсан болон оролцсон ажил, арга хэмжээг дүгнэсэн тайланг гаргаж ирүүлсэн байна.	Нотгомж баримтуудаар ажил, арга хэмжээ бүрийг нотолно. Нотгомж бүхий баримт материалыг тайланд хавсарган ирүүлсэн байна.

Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлэх				
24 Аяны үр дүн, тайланг боловсруулж, даргын зөвлөлд танилцуулах, нийт албан хаагч, олон нийтэд мэдээлэх	ЗУХ-ийн дарга Н.Ганболд, Ахлах мэргэжилтэн Х.Энхчимэг	2023.12.10-15	- Даргын зөвлөлд нэгдсэн тайланг дүгнэж танилцуулсан байна. - Авлигын зсрэг үйл ажиллагааны тайланд тусган тайлагнасан байна.	Нотгомж бүхий баримт материалгыг тайланд хавсаргасан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 10 сарын 25-ны өдрийн А/8 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

АЛБАН ХААГЧДЫН СУДАЛБАЛ ЗОХИХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТЫН ЖАГСААЛТ

Нэг. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2020 он
3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он
4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2020 он
5. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996 он
7. Компанийн тухай хууль, 2011 он
8. Орон сууц хувьчлах тухай хууль, 1996 он
9. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он
10. Төрийн албаны тухай хууль, 2017 он
11. Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он
12. Төсвийн тухай хууль,
13. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, 2023 он
14. Авлигын эсрэг хууль, 2006 он
15. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012 он
16. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021 он
17. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
18. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003 он
19. Төрийн хэмнэлтийн тухай хууль, 2022 он
20. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019 он
21. Зөрчлийн тухай хууль, 2017 он
22. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020 он
23. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, 1995 он
24. Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016 он
25. Монгол хэлний тухай хууль, 2015 он
26. Байгууллагын нууцын тухай хууль, 1995 он
27. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, 2020 он
28. Цахим гарын үсгийн тухай хууль, 2021 он
29. Бусад

Хоёр. Дүрэм, журам, заавар, стандарт

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам (Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан)

2. Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам (Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан)
3. Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам (Засгийн газрын 2023 оны 86 дүгээр тогтоолоор батлагдсан)
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам (Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор батлагдсан)
5. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, (Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан)
6. Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам (Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан)
7. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан)
8. Стратеги төлөвлөгөө төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам (Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан)
9. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам (Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан)
10. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам (Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан)
11. Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам (Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан)
12. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам (ХЗДХ-ийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан)
13. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам (Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан)
14. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг (ТӨБЗГ-ын 2020 оны 53 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан)
15. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журам (ТӨБЗГ-ын даргын 2023 оны А/35 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан)
16. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам (ТӨБЗГ-ын даргын 2023 оны А/47 дугаар тушаалаар батлагдсан)
17. Бусад

_____ о О о _____